



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/м.

Амардалай

Сайн дурын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4, 10.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг түшиглэн орон нутагт объектын болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гал түймрийг унтраах чиг үүргийг хэрэгжүүлэх гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Хэсгийн дарга: Б.Баатарсүрэн (Багийн Засаг дарга)

Гишүүд:

Г.Сосорбурам (Багийн Засаг дарга)

П.Амгаланбаатар (Багийн Засаг дарга)

А.Алтансүх (ЗДТГ-ын сантехникч)

Ш.Мөнх-Эрдэнэ (Хүүхдийн цэцэрлэгийн жижүүр)

Г.Алтан-Очир (Сургуулийн сантехникч)

Л.Батсүх (ЭМТ-ийн галч)

Хоёр. Гал унтраах сайн дурын хэсгийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг тогтоож бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн гал түймэр унтраах хэсгийн даргад, үйл ажиллагааг удирдан зохион байгуулалтаар хангаж ажиллахыг штабын дарга бөгөөд Засаг даргын Тамгын газрын дарга (С.Нарантунгалаг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнд захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



2022-06-03 41